

Энэхүү ТМТ нь 2015 оны 10 сарын 22-ны өдрийн Англи хувилбарын орчуулга болно.



ASIAN DEVELOPMENT BANK

Монгол Улс: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээ үзүүлэх төсөл

Төслийн нэр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээ үзүүлэх төсөл
Төслийн дугаар	48076-001
Улс орон	Монгол Улс
Төслийн статус	Батлагдсан
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Техникийн туслалцаа
Хөрөнгийн эх үүсвэр / Хэмжээ	ТА 8850-MON: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээ үзүүлэх төсөл Ядуурлыг бууруулах Японы сан 1.0 сая ам.доллар
Стратегийн зорилт	Оролцоог хангасан эдийн засгийн өсөлт
Хөдөлгөгч хүчин зүйл	Засаглал ба чадавхийн хөгжил Мэдлэгт суурилсан шийдлүүд Түншлэлүүд
Салбар / Дэд салбар	Боловсрол – Сургуулийн өмнөх ба суурь боловсрол – нийгмийн хамгааллын санаачилгууд Эрүүл мэнд – Эрүүл мэндийн салбарын хөгжил ба шинэтгэл Төрийн удирдлага – Нийгмийн хамгааллын санаачилгууд
Жэндерийн тэгш байдал ба оролцоо	Жэндерийн оролцоог үр дүнтэй хангана
Агуулга	Санал болгож буй төсөл нь Улаанбаатар хот, аймгуудын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн оролцоог хангаж, тэдний төрийн үйлчилгээнд хамрагдах боломжийг сайжруулах замаар нийгмийн томоохон асуудлыг шийдвэрлэхэд нь Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Төслийн ерөнхий зорилго нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар тэдний бие даах чадварыг бэхжүүлж, эдийн засаг ба нийгэмд оруулах хувь нэмрийг нь нэмэгдүүлэхэд оршино. Засгийн газрын зүгээс НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах конвенци, Инчоны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь энэхүү төсөл дэмжлэг болно.
Төслийн үндэслэл ба Улс/Бүсийн	Төслийн хүрээнд (i) хөгжлийн бэрхшээлийн талаарх Монголчуудын дунд тогтсон, анагаах ухаан болон нийгмийн

стратегитай уялдсан байдал	өнцгөөс харах ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн энэхүү төслийн тухайд оролцогч талуудын нэгдсэн байр суурийг бий болгох, (ii) хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-д хүргэх нийгмийн халамжийг шинэчлэх зэрэг нарийн төвөгтэй асуудлын шийдлийг боловсруулах, (iii) төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай боловч хомс байдаг, ХБИ-ийн талаарх мэдээллийг цуглуулах, бодит суурь өгөгдлийг тодорхойлох, (iv) төслийн төлөвлөлтөд олон улсын шилдэг туршлагыг тусгах, (v) дүн шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулан, Ерөнхийлөгчид зөвлөмж хүргүүлэх зорилгоор Төслийн бэлтгэлийн техникийн туслалцаа (ТТ)-г хэрэгжүүлэх болно.
----------------------------	--

Үр нөлөө

Төслийн үр дагавар

Үр дагаврын тайлбар

Үр дагаварт хүрэх явц

Хэрэгжилтийн явц

Төслийн үр дүнгийн тайлбар

Хэрэгжилтийн явцын статус (Үр дүн, Үйл ажиллагаа, Саад бэрхшээл)

Газарзүйн байрлал

Байгаль орчин, нийгмийн асуудлын товчоон

Байгаль орчин

Албадан

нүүлгэн

шилжүүлэлт

Уугуул иргэд

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед	Оролцоотой хөгжлийг хангах үүднээс, ХБИ болон ХБИБ-уудыг төслийн бүх шатанд оролцогч тал, шийдвэр гаргагч, үр дүнг хүртэгчээр хамруулна. Төслийн судалгааны шатанд, ХБИ-ийн бүлэглэлүүдийг төлөөлөх 20 гаруй ХБИБ-уудтай хэлэлцүүлэг хийсэн бөгөөд тэдний санал зөвлөгөөг төслийн агуулгад тусгасан болно.
--------------------------	--

Төслийн хэрэгжилтийн үед	ТТ-ны зөвлөхүүд оролцоог хангасан зөвшилцлийн аргачлалыг ашиглан төслийн хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч агентлагууд, салбар дундын ажлын хэсэг, төслийн бэлтгэлд зориулан байгуулж болзошгүй дэд хороодтой нягт хамтран ажиллаж, томилогдсон төлөөлөлд нь ажлаа тайлагнана. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар ажилладаг иргэний нийгмийн байгууллага, олон улсын хөгжлийн түнш байгууллагуудыг ТТ-ны боловсруулалт, хэрэгжилтийн шатанд өргөнөөр оролцуулна. ТТ-ны хэрэгжилт эхлэх үед, ТТ-ны хүрээнд хийгдэх ажилд ашиглагдах эхний үеийн мэдээлэл, өгөгдлийг цуглуулах зорилгоор, мөн түүнчлэн хэрэгжилтийн дунд шатанд ажлын явцыг тайлагнах, төслийн төлөвлөлт, мониторингийн хүрээг зөвшилцөх зорилгоор оролцогч талуудыг хамарсан зөвлөгөөн, хэлэлцүүлгүүдийг
--------------------------	--

зохион байгуулах болно. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар ажилладаг мэргэжилтнүүд, ХБИ, иргэдийн төлөөлөл, орон нутаг, төвийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудтай фокус бүлгийн цуврал уулзалт, ганцаарчилсан ярилцлагуудыг хийхээр төлөвлөсөн.

Бизнесийн боломж

Зөвлөх үйлчилгээ	АХБ нь үндэсний (28 хүн-сар) болон олон улсын зөвлөх (24 хүн-сар) үйлчилгээ авах зорилгоор зөвлөх үйлчилгээний компанитай хамтран ажиллана. Зөвлөхүүд ХАХНХЯ болон АХБ-д тайлагнана. Зөвлөх үйлчилгээний компанийг сонгон шалгаруулахад АХБ-ын Зөвлөх үйлчилгээ авах удирдамж (2013 оны хувилбар болон нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийг даган мөрдөж, хялбарчилсан техникийн санал, чанар-өртгийн шалгуурыг 80:20 стандарт харьцааг баримтлан шийдвэрлэнэ.
Худалдан авалт	ТТ-ны хүрээнд хийгдэх тоног төхөөрөмжийн худалдан авалтыг АХБ-ны Худалдан авалтын удирдамж (2013 оны хувилбар болон нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийн дагуу хийж гүйцэтгэнэ. Тоног төхөөрөмжийг ТТ дуусах даруйд төслийн хэрэгжүүлэгч агентлагт шилжүүлнэ.
АХБ-ын хариуцсан Ажилтан	Клод Бодарт
АХБ-ны хариуцсан Газар	Зүүн Азийн Газар
АХБ-ны хариуцсан Хэлтэс	Хот байгуулалт ба Нийгмийн салбарын Хэлтэс, ЗАГ
Хэрэгжүүлэгч агентлаг	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам Засгийн газрын байр-2, Нэгдсэн үндэстний гудамж 5, Улаанбаатар-15160, Монгол Улс

Хуваарь

Концепцийг батлах	-
Урьдчилсан судалгаа	-
Менежментийн хяналтын уулзалт	-
Батлагдсан	2014 оны 12 сарын 12
Сүүлд хийсэн хяналт	-
ТМТ-г шинэчилсэн	2015 оны 9 сарын 11

ТА 8850-MON

		Үе шатууд					Хаасан		
Хүчин төгөлдөр болсон		Хүчин төгөлдөр болсон		Хүчин төгөлдөр болсон		Анхны Өөрчилсөн Бодит			
2014.12.12		2015.08.11		2015.08.11		2015.11.30 2016.07.30 -			
АХБ		Санхүүгийн төлөвлөгөө/ТТ-ны ашиглалт					Хуримтлагдсан олголтууд		
Хамтарсан санхүүжилт		ЗГ	Түнш Үр ашгийг Төслийн хүртэгчид спонсор		Бусад	Нийт		Огноо	Дүн
0.00	1,000,000.00	0.00	0.00	0.00	0.00	1,000,000.00	2014.12.12	0.00	

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг. ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай байдаг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба бэлэн болсон үед нь нэмж оруулдаг. Санал болгож байгаа төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа нэгэн амлалт, баталгаа өгөхгүй. АХБ нь өндөр чанарын мэдээллийн контент гаргахыг эрмэлзсэн хэдий ч тухайн мэдээллийг “байгаагаар нь” ойлговол зохих бөгөөд арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүй. Нэн ялангуяа, тайланд агуулагдсан мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн болох талаар ямар нэгэн баталгаа эсвэл мэдэгдэл гаргаагүй болно.